**ХАН-УУЛ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ**

ХАН УУЛ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН 2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

2025 оны 06 дугаар сарын 15 Улаанбаатар хот

| Шийдвэрийн дэс, дугаар | Зүйл заалтын дэс дугаар | Шийдвэрийн нэр, огноо, дугаар | Заалтын агуулга | Биелэлт | хувь | Хэрэгжүүлэх байгууллага | Тасарсан болон удааширч байгаа шалтгаан |
|---|---|---|---|---|---|---|---|
| **НЭГ. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ** | | | | | | | |
| **ХОЁР. УИХ-ЫН ТОГТООЛ** | | | | | | | |
| 1 | 1.1.13 | Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай 2024-05-16 Дугаар: 46 | 2.Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг тогтоосон хугацаанд хэрэгжүүлж, хэрэгжилтийг жил бүрийн 02 дугаар сарын 01-ний өдрийн дотор Засгийн газрын Хэрэг эрхлэх газар болон Авлигатай тэмцэх газарт тус тус тайлагнаж ажиллахыг Засгийн газрын гишүүд, агентлаг, аймаг, нийслэлийн Засаг дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын газар, Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хороо, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллага, төрийн болон төрийн өмчийн | 2025 оны Хан-Уул эрүүл мэндийн төвийн Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.<br>Авлигын эсрэг төрийн болон төрийн бус, хувийн хэвшлийн байгууллагуудаас гаргасан санал санаачлагад нэгдэн дотоод групп, веб хуудсанд мэдээллийг тухай бүр оруулсан. Мөн Авилгын эсрэг сургалтыг зохион байгуулан албан хаагчдад Авлигын эсрэг тараах материал танилцуулан товч мэдээлэл олгосон. Хуулийн хүрээнд байгууллагын дарга болон холбогдох удирдах албан тушаалтны хөрөнгө оруулгын мэдүүлгийг гаргуулан, хуулийн хугацаанд багтаан бөглөсөн 2025 оны 01 сарын 14-ны өдрийн А/03 Ажлын сахилга хариуцлагыг | 90% | Эрүүл мэндийн төв | - |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | оролцоотой хуулийн этгээдийн удирдлагад тус тус даалгаж, Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим, иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн байгууллагад зөвлөсүгэй. | сайжруулах тухай тушаалыг баталж хавсралтын 5-д заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байна. Төвийн албан хаагчдад авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэх эрсдэлийг арилгах, авлига, ашиг сонирхлын зөрчил, иргэнд суртал, шударга бус байдал гаргахгүй байх талаар соён гэгээрүүлэх ажлыг байгууллагынхаа хэмжээнд зохион байгуулж нийт ажилчдад нөлөөллийн үйл ажиллагааг цахим орчинд доорх агуулгаар зохион байгуулсан. Үүнд<br>- Авилгын эсрэг тоны оролцоо<br>- Авилгагүй нийгмийн төлөө хамтдаа<br>- Авилгатай тэмцэх, урьдчилан сэргийлэх нь:<br>- Авилгатай тэмцэхэд таны хувь нэмэр<br>гэсэн агуулгаар нийт тус тус оруулсан. 2025 оны 01 сарын 14-ны өдөр 100 эмчид авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэх эрсдэлийг арилгах, авлига, ашиг сонирхлын зөрчил, иргэнд суртал, шударга бус байдал гаргахгүй байх талаар соён гэгээрүүлэх сургалтыг зохион байгуулсан. 2025 он 2 сард эмнэлгийн үйлчлүүлэгч авлигын талаарх танилцуулах метриалыг 100 иргэнд тарааж танилцуулсан. . | | | |
| УИХ-ЫН 1 ТОГТООЛЫН 1 ЗААЛТЫН БИЕЛЭЛТ | | | | | 90% | | |
| УИХ-ЫН БАЙНГЫН ХОРООНЫ 1 ТОГТООЛЫН 1 ЗААЛТЫН БИЕЛЭЛТ | | | | | | | |
| **ДӨРӨВ. ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ** | | | | | | | |
| 2 | 14.1.8 | Монгол бичгийн хэрэглээг | 3. Албан байгууллага, аж ахуйн нэгж, барилга байгууламж, гудамж, талбайн нэр хаяг, бүтээгдэхүүний шошго, | Эрүүл мэндийн төвийн нэр томьёог орчуулах, шинээр үүсгэх, жигдлэх, ажлыг зохион 2025 онд үе шаттайгаар зохион | 70% | | - |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх туай 2018-05-23 Дугаар 2018_46 | бэлгэ тэмдэг, зар сурталчилгаа зэргийг үндэсний бичгээр бичиж хэвшүүлэх ажлыг зохион байгуулах; үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлж, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн уг үйл ажиллагаа, аливаа идэвх санаачилгыг хөхиүлэн дэмжиж, урамшуулж ажиллахыг бүх шатны Засаг дарга нар, холбогдох төрийн байгууллагуудад чиглэл болгосугай. | байгуулан ажиллаж. Байгууллагын гадна болон дотно өрөө тасалгааны хаягжилтийг хос бичгээр жигдлэх, тусгай хэрэгцээт иргэдэд зориулан брайл үсгээр болгон нэг загварт оруулах ажлыг хэрэгжүүлсэн мөн гадна хаягжилтыг 2025 оны 02 дугаар улиралд хийхээр 3 байгууллагын үнийн судалгааг авсан байна. | | Эрүүл мэндийн төв | |
| | 15.19 | | 4. Энэхүү зарлигт дурдсан ажлуудад болон монгол хэл, бичиг үсгээ сурч судлах, өвлөх, өвлүүлэх, эзэмших, хэрэглэх, хамгаалах, хөгжүүлэх талаар идэвх санаачилга гарган ажиллахыг иргэд, олон нийт, эрдэмтэн судлаачид, шинжлэх ухааны ба хэвлэл мэдээллийн байгууллага, төрийн ба төрийн бус байгууллагуудад уриалсугай. | 2025 оны 04 сарын 14 өдөр “Төлөвлөгөө батлан хэрэгжүүлж ажиллах тухай” А/53 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар сургалтын төлөвлөгөөнд эмнэлгийн мэргэжилтнүүдэд монгол бичгийн албан хөтлөлт түүнийг хэрэгжүүлэх хүрээнд төлөвлөгөө гарган эхний байдлаар судалгаа авч сургалтын гарааны үнэлгээ хийлгэхээр төлөвлөн ажиллаж байна. Кирилл болон монгол бичгийн судалгааг нийт 113 албан хаагч оролцсоноос маш сайн 12 сайн 30 дунд зэрэг 50, огт мэдэхгүй 21 албан хаагчийн судалгаа гарсан. Судалгаанд тулгуурлан огт мэдэхгүй 21, дунд зэрэг 50 ажилтныг 2 хуваан 2025 оны 06 дугаар сарын 06-ний өдөр анхан шатны сургалтыг зохион байгуулсан. Албан хэрэг хөтлөлтийг 2025 оны 04 сарын 01-ны өдрөөс монгол бичгээр хосолсон хөтөлж эхлэсэн. | 70 % | | - |
| ЕРӨНХИЙЛӨГЧИЙН 1 ЗАРЛИГИЙН 2 ЗААЛТЫН БИЕЛЭЛТ | | | | | 70% | | |
| **ДОЛОО. ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ** | | | | | | | |
| 3 | 15.45 | Монгол хэлний тухай | 5. Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангах дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн | Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангах, Төрийн албан хэрэг хөтлөлтийг крилл болон үндэсний хос | 70% | | - |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022-01-05 Дугаар 2022_7 | ерөнхийлөн болон шууд захирагч нарт тус тус даалгасугай: 5.1. эрх бүхий судалгааны байгууллагатай хамтран салбарын мэргэжлийн нэр томьёог орчуулах, шинээр үүсгэх, жигдлэх, толилох ажлыг зохион байгуулах, нийтийн хэрэглээнд нэвтрүүлэх; | бичгээр хөтлөн явуулах ажлын хүрээнд Нийслэлийн архивын газарт тушаал болон албан бичгийн хэвлэмэл хуудсын захиалга өгч хэвлүүлсэн. Байгууллагын сургалтын төлөвлөгөөнд төрийн албан хаагчдын монгол хэл, үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх зорилгоор Монгол бичгийн сургалтыг тусган ажиллаж байна. Кирилл болон монгол бичгийн судалгааг нийт 113 албан хаагч оролцсоноос маш сайн 12 сайн 30 дунд зэрэг 50, огт мэдэхгүй 21 албан хаагчийн судалгаа гарсан. Судалгаанд тулгуурлан огт мэдэхгүй 21, дунд зэрэг 50 ажилтныг 2 хуваан 2025 оны 06 дугаар сарын 06-ний өдөр анхан шатны сургалтыг зохион байгуулсан. | | Эрүүл мэндийн төв | |
| | 16.46 | | 5.2. төрийн байгууллагын цахим хуудас, сонин хэвлэлд нийтэлж байгаа мэдээ, мэдээллийг 2022 оноос эхлэн кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн нийтэлж хэвшүүлэх; | Байгууллагын цахим хуудсын нэрийг крилл болон үндэсний хос бичгээр хослон хөтөлж байгаа бөгөөд цаашид монгол бичгээр зэрэгцүүлэн нийтэлж, хос бичгээр хөтлөн хэрэгжүүлж байна. | 75 % | | - |
| | 15.47 | | 5.3. төрийн байгууллагын шийдвэр, албан бичгийг энэ тогтоолын 4-т заасан дүрэм, журам, заавар, стандартын дагуу хос бичгээр хөтлөх ажлыг турших; | Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангах, Төрийн албан хэрэг хөтлөлтийг крилл болон үндэсний хос бичгээр хөтлөн явуулах ажлын хүрээнд төрийн байгууллагын шийдвэр, албан бичгийг энэ тогтоолын 4-т заасан дүрэм, журам, заавар, стандартын дагуу хос бичгээр хөтлөж хэвшсэн. | 100% | | - |
| | 15.48 | | 5.4. төрийн албан хаагчдын монгол хэл, үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах, сургалтын хөтөлбөр, | 2025 оны 04 сарын 14 өдөр “Төлөвлөгөө батлан хэрэгжүүлж ажиллах тухай” А/53 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар сургалтын төлөвлөгөөнд эмнэлгийн мэргэжилтнүүдэд монгол бичгийн албан | 90% | | - |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | төлөвлөгөөг жил бүр баталж мөрдүүлэх; | хөтлөлт түүнийг хэрэгжүүлэх хүрээнд төлөвлөгөө гарган эхний байдлаар судалгаа авч сургалтын гарааны үнэлгээ хийлгэхээр төлөвлөн ажиллаж байна. Кирилл болон монгол бичгийн судалгааг нийт 113 албан хаагч оролцсоноос маш сайн 12 сайн 30 дунд зэрэг 50, огт мэдэхгүй 21 албан хаагчийн судалгаа гарсан. Сургалтыг үе шаттайгаар зохион байгуулж байна. | | | |
| | 15.49 | | 5.5. төрийн байгууллагын гадна болон өрөө тасалгааны хаяг, албан хаагчдын нэрийн хуудсыг монгол бичгээр үйлдэж, хэвшүүлэх. | Эрүүл мэндийн төвийн 1-4 давхарын эмч нарийн өрөө, тасалгаа тасгийн нэршлийг хосолсон монгол бичиг болон брайл нэг загвараар хаягжилтийг бүрэн хийж дуусгасан. Төвийн дарга болон бусад удирдах ажилтны нэрийн хуудсыг монгол бичгээр болгосон. | 70% | | - |
| 4 | 15.50 | Төрийн албан хаагчийн богино хугацааны сургалт зохион байгуулах тухай 2022-04-06 Дугаар: 139 | 3.Төрийн албан хаагчийн богино болон дунд хугацааны сургалтын агуулга, хөтөлбөрт 2023 оноос эхлэн уг сургалтыг нэмж тусган батлуулах арга хэмжээ авахыг “Удирдлагын академи” төрийн өмчит үйлдвэрийн газар (Д.Сүрэнчимэг)-т, сургалт зохион байгуулахтай холбоотой зардлыг “Удирдлагын академи”-ийн төсөвт тусгаж байхыг Сангийн сайд Б.Жавхланд, тус сургалтад хамруулах албан хаагчдынхаа зардлыг тухайн жилийн төсвийн төсөлд тусгаж байхыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт тус тус даалгасугай. | “Удирдлагын академи” төрийн өмчит үйлдвэрийн газар сургалтад одоогоор хамрагдсан эмч, эмнэлгийн мэргэжилтэн байхгүй байгаа бөгөөд статистикч эмч Дэлгэрцэцэг өөрийн зардлаар суралцаж байгаа болно. Цаашид байгууллага хэрэгцээ шаардлагад үндэслэн сургалтын төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. | 70 % | Эрүүл мэндийн төв | - |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 5 | 15. | Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн зарим арга хэмжээний тухай 2023-08-30 Дугаар 2023_321 | 2. Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх арга хэмжээг харьяалах салбар, нутаг дэвсгэртээ зохион байгуулж, үр дүнг тооцож ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгож, шаардагдах зардлыг төсвийн ерөнхийлөн захирагч нарын саналыг харгалзан улсын нэгдсэн төсвийн төсөлд тусган, хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхланд даалгасугай. | Монгол Улсын стандарт “Төрийн байгууллагын вэбсайт тавих шаардлага” MNS6285: 2017 дагуу цахим хуудасны агуулга, бүтцийг тогтоон сүүлийн 5 жил шинэчлэн хөтөлж байна. Байгууллагын албан ёсны http://huemt.ub.gov.mn/, http://www.huemn.ub.gov.mn/ цахим хуудсанд 134 мэдээ, мэдээллийг байршуулж 2025 оны хагас жилд 186912 хэрэглэгчийн хандалтыг авсан байна. Байгууллагын шинээр хэрэгжүүлж байгаа 10 үйл ажиллагааны талаар 10 рийлийг давхардсан тоогоор 700 зуун мянга гаруй иргэний үзэлтийг авсан. | 70% | Эрүүл мэндийн төв | - |
| 6 | 16. | Бүх нийтийн цахим ур чадварын бүтцийн хүрээ батлах тухай 2024-04-03 Дугаар:141 | 2.”Бүх нийтийн цахим ур чадварын бүтцийн хүрээ”-нд заасан чадамжуудыг нарийвчлан судалж, цахим ур чадварыг үнэлэх, аргачлал, сургалтын хөтөлбөр боловсруулж, түгээх ажлыг зохион байгуулахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Л.Энх-Амгалан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, уг ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга нарт даалгасугай. | Эрүүл мэндийн хөгжлийн төвийн цахим санд 106 эмч, сувилагчийг байршуулж health.gov.mn программ хангамжийн эрх нээж сургалт явуулж цахим жор тогтмол олгож байна. Эмнэлгийн нэгдсэн систем ихэйлт программын эрх 180 ажилтанд олгож програм хангамжийн амбулатори, стационари, яаралтай тусламж, миний үйлчилгээ, сувилгаа, эм бараа материал, даатгал, статистик гэсэн үндсэн модулиудын хүрээнд тогтмол сургалтыг хийж эмнэлгийн тусламж үйлчилгээ, өвчтөний түүх бүрэн цахимжсан байна. | 70% | Эрүүл мэндийн төв | |
| 7 | 17. | Засгийн газрын хүний нөөцийн бодлогыг дэмжих цахим | “Засгийн газрын хүний нөөцийн бодлогыг дэмжих цахим систем”-ийг ашиглан эрхлэх асуудлынхаа хүрээндээ төрийн албан хаагчийн мэдээллийн бүрдүүлэлт, үнэн зөв байдалд хяналт тавьж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн | 1. Хүний нөөцийн систем https://hrm.csc.gov.mn/ дээр байгууллагад ажилд орж байгаа ажилчдын бүртгэлийг хур системээс татан<br>2. ННЗБ-УУДЫН ДОТООД УДИРДЛАГЫН СИСТЕМ | 100% | Эрүүл мэндийн төв | - |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | системийн талаар авах арга хэмжээний тухай 2024-05-08 Дугаар 2024_196 | газрын агентлагийн дарга, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай | https://erp.ulaanbaatar.mn/ дээр байгууллагын ажилчдын мэдээллийг бүтцийн дагуу албан тушаалын нэршлийг нэг бүрчлэн бүртгэж цагийн хуваарийг цаашид сургалт ээлжийн амралтын хуваарийг оруулан<br>3. Эрүүл мэндийн хөгжлийн төвийн https://hr.hdc.gov.mn/ систем дээр эмнэлгийн эмч, сувилагч мэргэжилтэнгийн бүртгэлийг хийж байгаа бөгөөд одоогоор 214 ажилтны бүртгэлийг баталгаажуулсан байна. | | | |
| | 18. | ЗГ-ЫН 5 ТОГТООЛЫН 9 ЗААЛТЫН БИЕЛЭЛТ | | | 80% | | |
| **НАЙМ. ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ** | | | | | | | |
| 8 | 19. | 2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн хуралдааны 15 дугаар тэмдэглэлд: 2024-04-17 | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан байнга ил тод, нээлттэй байлгах мэдээллийг "Нээлттэй мэдээллийн систем (shilen.gov.mn)-д байршуулах ажлыг хариуцсан салбар, нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж, мэдээллийг тухай бүр шинэчилж ажиллахыг төрийн болон орон нутгийн өмчит оролцоотой байгууллагуудын удирдлага, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт | Байгууллагын санхүүгийн ил тод байдлыг хангах, иргэнд сууртлыг багасгах, авилга үүсэх эрсдлийг бууруулах ажлын хүрээнд<br>• Төсвийн гүйцэтгэлийн мэдээг 5 удаа,<br>• Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээг 5 удаа,<br>• Батлагдсан төсөв 1 удаа<br>•Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл 5 удаа бусад холбогдох мэдээллүүдийг шилэн дансны цахим хуудсанд https://www.shilendans.gov.mn/org/-нд тогтмол байршуулж шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллаж байна.<br>Шилэн дансанд мэдээллийг тогтмол байршуулахаас гадна Хан-Уул эрүүл | 91% | Эрүүл мэндийн төв | - |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | мэндийн төв нь холбогдох мэдээллүүдийг байгууллагын цахим хуудас http://www.huemn.ub.gov.mn сайт болон байгууллагын ил тод байдлын самбарт тухай бүр байршуулсан байна. | | | |
| ЗГ-ЫН 1 ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН 1 ЗААЛТЫН БИЕЛЭЛТ | | | | | 91% | | |
| Нийт 8 тогтоолын холбогдох 13 заалтын биелэлт | | | | | 83% | | |

ХЯНАСАН:
СТРАТЕГИ, БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН
АЛБАНЫ ДАРГА Т.БУЛГАНТАМИР

НЭГТГЭСЭН:
ГАДААД ХАРИЛЦАА, БОРЛУУЛАЛТ, ТӨСӨЛ
ХӨТӨЛБӨР ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Г.НЯМРАГЧАА